



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянзүрх дүүргийн Нийтлэг үйлчилгээний газар нэг ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2024/67/НА-СТА-ОНА

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2024 он</p>	<p>Гэрээгээр гүйцэтгэсэн: Сүлд-Аудит ХХК Захирал: ахлах аудитор Ч.Гүндбаяр Утас: 70118016 Цахим хаяг: <a href="mailto:info@suld-audit.mn">info@suld-audit.mn</a> Чанарын хяналтын менежер: С.Лхагважав Утас: 99182632 Цахим хаяг: <a href="mailto:info@suld-audit.mn">info@suld-audit.mn</a> Аудитор: Д.Мөнхтуяа Утас: 99781289 Цахим хаяг: <a href="mailto:info@suld-audit.mn">info@suld-audit.mn</a></p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024.03.15 № 559

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН НИЙТЛЭГ  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР НЭГ  
ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ  
Д.ӨЛЗИЙДЭМБЭРЭЛ ТАНАА

### АУДИТЫН ДҮГНЭЛТ

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Баянзүрх дүүргийн Нийтлэг үйлчилгээний газар нэг ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Баянзүрх дүүргийн Нийтлэг үйлчилгээний газар нэг ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Аудитын онцолсон хэсэг

Баянзүрх дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 72 дугаар тогтоолын дагуу Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, төр-хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх, бизнесийн үйл ажиллагаанд төрийн оролцоог багасгах зорилгоор Баянзүрх дүүргийн Нийтлэг үйлчилгээний газар нэг ОНӨААТҮГ-ыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх сонгон шалгаруулалтын үр дүн гарах хүртэлх хугацаанд үйл ажиллагааг үргэлжлүүлж, татан буулгах тухай шийдвэр гаргасан байна.

#### Аудитын гол асуудал

Баянзүрх дүүргийн Нийтлэг үйлчилгээний газар нэг ОНӨААТҮГ-ыг татан буулгах шийдвэр гарсантай холбоотой шатахуун худалдан авалт болон хог тээврийн машин түрээслэх тендерийг цуцалж, 300.4 сая төгрөгийн шатахуун, 253.8 сая төгрөгийн машины түрээсийн гэрээ шууд байгуулсан байна.

#### Бусад асуудлын хэсэг

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд 3 зорилтын

0020000155

хүрээнд 18 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс бүрэн хангалттай 64.2 хувийн гүйцэтгэлтэй биелүүлсэн гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

		<i>/төгрөгөөр/</i>	
Д/Д	Балансын зүйл	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	27,688.88	19,030.42
1.1.2	Дансны авлага	19,492,403.97	18,709,740.00
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага		
1.1.4	Бусад авлага		
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	37,568,660.00	3,984,760.00
1.1.7	Урьдчилж төлсөн зардал тооцоо		
1.1.20	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>57,088,752.85</b>	<b>22,713,530.42</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	628,637,129.00	736,421,218.21
1.2.2	Биет бус хөрөгө		
1.2.20	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>628,637,129.00</b>	<b>736,421,218.21</b>
1.3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>685,725,881.85</b>	<b>759,134,748.63</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>ӨР ТӨЛБӨР</b>		
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг		
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өр	24,902,870.40	56,111,949.80
2.1.1.4	НДШ-ийн өглөг	52,075,435.12	
2.1.1.5	Богино хугацаат зээл		
2.1.1.6	Хүүний өглөг		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	560,461,351.99	679,221,608.88
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	15,577,615.76	24,089,087.00
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө ( борлуулах бүлэг хөрөнгө )- нд хамаарах өр төлбөр		
2.1.1.20	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>653,017,723.27</b>	<b>759,422,645.67</b>
2.2	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>653,017,273.27</b>	<b>759,422,645.67</b>
2.3	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Төрийн өмч	3,402,950.00	3,402,950.00
2.3.2	Хувийн өмч		
2.3.3	Хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	190,967,874.00	190,967,874.00
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг		
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(161,662,215.41)	(194,658,721.04)
2.3.20	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>32,708,608.59</b>	<b>(287,897.04)</b>
2.4	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>685,725,881.86</b>	<b>759,134,748.63</b>

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

Д/Д	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого ( цэвэр )	2,452,196,550.17	1,834,421,680.88
3	Борлуулалтын өртөг		
4	<b>Нийт ашиг ( алдагдал )</b>	<b>2,452,196,550.17</b>	<b>1,834,421,680.88</b>
5	Түрээсийн орлого		
6	Хүүгийн орлого		
7	Ногдол ашгийн орлого		
8	Эрхийн шимтгэлийн орлого		
9	Бусад орлого		113,153,218.71
10	Борлуулалт, маркетингийн зардал		
11	Ерөнхий ба удирдлагын зардал	2,393,337,704.34	1,980,571,405.25
12	Санхүүгийн зардал		
13	Бусад зардал		
14	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
15	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(1,508,333.04)	
16	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
17	Хөрөнгө орлуулалт борлуулсанаас үүссэн олз (гарз)		
18	Бусад ашиг ( алдагдал )	(2,697,710.00)	
19	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>54,652,802.79</b>	<b>(32,996,505.66)</b>
20	Орлогын татварын зардал		
21	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>54,652,802.79</b>	<b>(32,996,505.66)</b>
22	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
23	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>54,652,802.79</b>	<b>(32,996,505.66)</b>
24	Бусад дэлгэрэнгүй орлого		
25	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэлийн зөрүү		
26	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
27	Бусад олз (гарз)		
28	<b>Орлогын нийт дүн</b>	<b>54,652,802.79</b>	<b>(32,996,505.66)</b>
29	Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг (алдагдал)		

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Хувьцаат капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан дүн	Нийт дүн
1	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>3,402,950.00</b>	<b>190,967,874.00</b>	<b>(216,315,018.20)</b>	<b>(21,944,194.20)</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
3	<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>3.402.950.00</b>	<b>190,967,874.00</b>	<b>(216,315,018.20)</b>	<b>(21,944,194.20)</b>
4	Бусад дэлгэрэнгүй орлого				
5	Өмчид гарсан өөрчлөлт				
6	Зарласан ногдол ашиг				
7	Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )			54,652,802.79	54,652,802.79
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				
9	<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>3,402,950.00</b>	<b>190,967,874.00</b>	<b>(161,662,215.41)</b>	<b>32,708,608.59</b>
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
11	<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>3,402,950.00</b>	<b>190,967,874.00</b>	<b>(161,662,215.41)</b>	<b>32,708,608.59</b>
12	Бусад дэлгэрэнгүй орлого				
13	Өмчид гарсан өөрчлөлт				
14	Зарласан ногдол ашиг				
15	Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )			(32,996,505.63)	(32,996,505.63)
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				
	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>3,402,950.00</b>	<b>190,967,874.00</b>	<b>(194,658,721.04)</b>	<b>(287,897.04)</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн</b>	<b>2,377,551,300.00</b>	<b>1,842,585,156.51</b>
	Бараа борлуулсан үйлчилгээний орлого	2,377,551,300.00	1,834,421,680.88
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
	Буцаан авсан албан татвар		
	Татаас санхүүжилтийн орлого		
	Бусад мөнгөн орлого		8,163,475.63
1.2	Мөнгөн зарлагын дүн	2,377,542,735.49	1,842,593,814.97
	Ажилчдад төлсөн	721,007,994.88	510,616,855.60
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	226,096,957.28	198,755,301.00
	Бараа материал худалдан авахад төлсөн мөнгө	69,072,119.00	22,514,993.00
	Ашиглалтын зардалд төлсөн	363,511,711.00	347,474,859.00
	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	722,463,405.08	616,054,738.00
	Хүүний төлбөрт төлсөн		
	Татварын байгууллагад төлсөн		
	Даатгалын төлбөрт төлсөн		
	Бусад мөнгөн зарлага	275,390,548.25	147,177,068.37
1.3	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>8,564.51</b>	<b>(8,658.46)</b>
4	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>8,564.51</b>	<b>(8,658.46)</b>
5.1	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>19,124.37</b>	<b>27,688.88</b>
5.2	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>27,688.88</b>	<b>19,030.42</b>

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2022 оны гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү + хэмнэсэн -хэтэрсэн	Хувь
1	<b>Нийт санхүүжилт</b>	<b>2,452,196,550.17</b>	<b>2,400,000,000.00</b>	<b>1,947,574,899.62</b>	<b>452,425,100.38</b>	<b>81.1</b>
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	2,255,555,000.00	2,400,000,000.00	1,833,333,400.00	566,666,600.00	76.4
	Татварын бус орлого	196,641,550.17	-	114,241,499.62	(114,241,499.62)	0.0
2	<b>Нийт зардал</b>	<b>2,393,337,704.00</b>	<b>2,400,000,000.00</b>	<b>1,980,571,405.25</b>	<b>419,428,594.75</b>	<b>82.5</b>
3	Цалин	821,927,764.00	887,000,000.00	610,939,127.97	276,060,872.03	68.9
4	НДШ зардал	119,596,134.00	128,615,000.00	88,554,240.88	40,060,759.12	68.9
5	Гэрэл, цахилгаан	2,413,711.00	3,000,000.00	2,565,109.00	434,891.00	85.5
6	Түлш, халаалт	2,580,000.00	2,700,000.00	1,747,500.00	952,500.00	64.7
7	Цэвэр, бохир ус	2,241,000.00	2,400,000.00	1,502,000.00	898,000.00	62.6
8	Байрны түрээс	334,595,000.00	361,080,000.00	341,929,000.00	19,151,000.00	94.7
9	Бичиг хэрэг	4,276,346.00	4,500,000.00	2,387,790.00	2,112,210.00	53.1
10	Тээвэр, шатахуун	384,817,195.00	330,000,000.00	337,092,498.00	(7,092,498.00)	102.1
11	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,080,000.00	1,273,880.00	990,000.00	283,880.00	77.7
12	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	64,228,849.00	80,000,000.00	46,377,893.00	33,622,107.00	58.0
13	Аж ахуйн материал худалдан авах зардал	16,909,520.00	17,000,000.00	1,917,600.00	15,082,400.00	11.3
14	Нормативт зардал	6,162,000.00	7,431,120.00	-	7,431,120.00	0.0
15	Багаж, техник, хэрэгсэл	318,776,712.00	300,000,000.00	283,052,506.00	16,947,494.00	94.4
16	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил	220,079,726.00	140,000,000.00	136,043,729.61	3,956,270.39	97.2
17	Бараа үйлчилгээний бусад зардал	86,300,747.00	120,000,000.00	7,806,500.00	112,193,500.00	6.5
18	Элэгдлийн зардал		-	115,965,910.79	(115,965,910.79)	0.0
19	Бусад урсгал шилжүүлэг	7,353,000.00	15,000,000.00	1,700,000.00	13,300,000.00	11.3
20	<b>Нийт ашиг, алдагдал</b>	<b>58,858,846.17</b>	<b>-</b>	<b>(32,996,505.63)</b>	<b>32,996,505.63</b>	<b>0.0</b>
21	<b>Татварын зардал</b>	<b>4,206,043.00</b>			<b>-</b>	<b>0.0</b>
22	<b>Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/</b>	<b>54,652,803.17</b>	<b>-</b>	<b>(32,996,505.63)</b>	<b>32,996,505.63</b>	<b>0.0</b>

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 15,075.8 мянган төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад залрууллаа.

#### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Аудитын тайлангаас зөрүүтэй байна	1	60.9			1	60.9	1	60.9				
Авлага, өглөгийн тайланд сөрөг дүн байна	1	5,350.6			1	5,350.6	1	5,350.6				
Түрээсийн тооцоог буруу бичилт хийсэн	1	500.0			1	500.0	1	500.0				
ААНОАТ, орлогын дэлгэрэнгүй тайлан зөрүүтэй	1	9,164.3			1	9,164.3	1	9,164.3				
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>15,075.8</b>			<b>4</b>	<b>15,075.8</b>	<b>4</b>	<b>15,075.8</b>				

Аудитаар нийт 8,992.9 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрсэнд 2 зөвлөмж өгсөн.

#### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
И-баримт шивэгдээгүй	1	8,530.8					1	8,530.8				
Авлага, өглөгийн тооцоо нийлэлт	1	462.1					1	462.1				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>8,992.9</b>					<b>2</b>	<b>8,992.9</b>				

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 554,223.0 мянган төгрөгийн 1 зөрчил илэрснийг зөвлөмж хүргүүлсэн.

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Худалдан авалт	1	554,223.0					1	554,223.0
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>554,223.0</b>					<b>1</b>	<b>554,223.0</b>